



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 160 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 160 дугаар тушаалаар батлагдсан "Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ын 4.5 дахь заалтын дагуу мэргэжлийн зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргыг сонгож газрын даргын тушаалаар батлуулахыг орлогч дарга А.Батбаяр, Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ж.Батсайхан, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн дарга Э.Баярмаа нарт даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын "Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/97 дугаар, 2017 оны 09 сарын 13-ны өдрийн А/218 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Ц.ГАНХҮҮ

08 190344

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 1/31 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн

№	Овог, нэр, утас	Байгууллага, албан тушаал	Мэргэжил, цол, зэрэг
1.	А.Батбаяр	ГЗБГЗЗГ-ын орлогч дарга	МТ-ийн инженер, Эрх зүйч, Удирдахуйн ухааны магистр, докторант
2.	С.Энхтуяа	ГЗБГЗЗГ-ын ЗУХАГ-ын ахлах мэргэжилтэн	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
3.	Б.Болормаа	ШУТИС, ГУУС-ийн Геодезийн салбарын багш	Геодезийн инженер, МУ-ын мэргэшсэн инженер
4.	Л.Баасанжав	Ахмад ажилтан	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
5.	Ч.Цэрэнбат	"Инженер геодези" ХХК-ийн захирал	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
6.	Г.Нарантуяа	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, ахлах байцаагч	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
7.	Ц.Дашзэвгэ	МГФЗЗХ-ны УЗ-ийн гишүүн	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
8.	П.Эрдэнэчимэг	ШУТИС, ГУУС-ийн Геодезийн салбарын багш	Геодезийн инженер, Доктор
9.	Т.Балжинням	ХААИС-ийн АБС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	МУ-ын зөвлөх инженер, Доктор.проф
10.	П.Алтанцэцэг	"Геосан" ХХК-ийн дэд захирал	Геодезийн инженер, МУ-ын мэргэшсэн инженер
11.	Д.Түвшинбаяр	ХААИС-ийн багш,	Зураг зүйч инженер, МУ-ын зөвлөх инженер, Доктор, дэд профессор
12.	Ч.Болорчулуун	МУИС-ийн ШУС, Газар зүйн тэнхмийн багш	Геодезийн инженер, МУ-ын мэргэшсэн инженер
13.	Я.Сандагдорж	Эм Пи Эм ХХК-ийн захирал	Зураг зүйн инженер, МУ-ын зөвлөх инженер
14.	О.Хосбаяр	ГФЗЗХ-ны тэргүүн	Геодезийн инженер, МУ-ын мэргэшсэн инженер
15.	Д.Мөнхцэцэг	ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-ийн дарга	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер